

2.11. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН, ОНОЛ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Түлхүүр үг: нийгмийн хөгжил, модернизац, тогтвортой хөгжил.

Орчин үед нийгмийн хөгжлийн асуудал ихээхэн өвөрмөц байдлаар тавигдах боллоо. Эдүгээ уг ойлголтыг “модернизаци” гэсэн утгаар авч үзэх хандлага ажиглагдаж байна. Энэ талаархи үзэл баримтлал, онол сургаал 1950-иад оны сүүл, 60-аад оны эхэн үеэс үүсэн бий болжээ. Энэ үед дэлхий дахин өмнөх үетэйгээ харьцуулахад асар хурдацтайгаар өөрчлөгдөн хөгжих болсон. Иймд энэхүү модернизацийн тухай нэгдсэн ойлголт, тэр дундаа орчин үеийн нийгмийн мөн чанарын тухай болон, түүний ямар процессын дунд төлөвшин тогтсон тухай үзэл баримтлал бий болгох зайлшгүй шаардлага хүн төрөлхтний өмнө тулгарчээ.

Модернизацийн онолыг баримтлагчид өнөөдөр нийгмийн модернизацийн талаар нэгдсэн нэг тодорхойлолт хараахан гаргаж ирээгүй байна. Энэ онолын гол төлөөлөгчид болох Смелзер, У.Ростоу, И.Н.Эйзенштадт, М.Вебер, Т.Парсонс нарын зэрэг эрдэмтэд өөр өөрийнхөөрөө модернизацийг тодорхойлж байна.

Тухайлбал Эйзенштадт модернизацийг “Баруун Европт болон хойд Америкт бий болсон улс төр, нийгэм, эдийн засгийн систем рүү чиглэсэн хувьсах үйл явц” гэж үзжээ.¹ Мөн модернизаци бол баруунжих үйл явц, дэвшил, орчин үеийн биш нийгэм маш энгийн хэлбэрээр орчин үеийн нийгэм рүү чиглэн буй үйл явц юм гэх зэргээр тодорхойлж байна.

Модернизацийн талаар манайд ч гэсэн тодорхой судалгаа хийгдэж буйг тэмдэглэх нь зүйтэй².

1970-аад оноос эхлэн тогтвортой хөгжил хэмээх ойлголт гарч дэлхийн улс орнуудын хөгжлийн гол чиг баримжаа үзэл баримтлал болж иржээ. Энэ баримтлалын үүднээс хүмүүсийн аж амьжиргааны түвшнийг дээшлүүлэхийг тогтвортой хөгжил буюу

¹ Eisenstadt S. Tradition, Change and Modernity. 1973, х.66

² Дашпүрэв Д. Этапы модернизации монгольского общества. УБ., 1995, х.173

тэнцвэртэй хөгжил гэж нэрлэх бөгөөд угтаа хүнийг тал бүрээр нь хөгжүүлэн дэвжээх, тогтвортой хөхүүлэн тэтгэж байна гэсэн утгатайгаар энэ ойлголт хэрэглэгдэж байна¹

Орчин үед байгаль орчны асуудал анхаарлын төвд тавигдах боллоо.

Хүн өөрийнхөө нийгэм, биологийн өсөлт, хөгжлийн явцдаа хийж бүтээсэн бүхнийг хөгжлийн үр дүн гэж үзэж болно.

Хүн, байгалийн хоорондын харилцаа буюу хөгжил, байгалийн харилцан үйлчлэлийн асуудал өнөөдөр чухал ач холбогдолтой болж байна. Нийгмийн хөгжилд байгаль эерэг, сөрөг нөлөө үзүүлж байгаа бол хөгжил нь эргээд байгальдаа зохицох шаардлагатай болж байна.

Сонгодог эдийн засгийн онолоор хөгжлийн үр дүнг дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлтөөр шалгуур болгон авч үзэх байдал тод харагддаг.

ДНБ-ний өсөлт нь байгаль орчны доройтол, цэвэр агаар, цэнгэг усны бохирдол, ан амьтны болон биологийн төрөл зүйлийн хомсдлыг илэрхийлэн гаргах боломжгүй юм.

Нэг талаас ДНБ-ний өсөлтийн статистик тоон үзүүлэлт нь тухайн улс орны хөгжлийг дангаараа илэрхийлж чадахгүйд хүрч байна. Үүний цаана чанарын үзүүлэлт гэж чухал зүйл бий. Энэхүү чанарын үзүүлэлтэд байгаль орчны төлөв байдал, хүн амын амьжиргааны түвшингийн асуудал гол байр суурь эзлэх ёстой. Саяхан болтол дэлхий дахины хэмжээгээр шинжлэх ухаан техникийн хувьсгал хүчтэй өрнөж байв. Хүн төрөлхтөн хөгжлийн өндөр түвшинд хүрлээ хэмээн ихээхэн шуугиж, өөрсдийгөө хөхүүлэн магтаж байлаа. Гэтэл энэ нь тоон үзүүлэлт болохоос биш чанарын хувьд байгаль дэлхийгээ сүйрэл рүү хөтөлсөн алхам болсныг саяхнаас л ойлгодог боллоо.

Түүхийн өнгөрсөн хугацаанд озоны цоорхой, дэлхийн дулаарал, далайн түвшний дээшлэлт, ган, цөлжилт, биологийн төрөл зүйлийн хомсдол, хүчиллэг бороо, удаа дараа тохиолдох байгалийн гамшиг зэрэг маш олон хурц асуудал бий болсон нь байгаль орчны талаар улс гүрэн бүс нутаг, дэлхийн улс орны гол бодлого, анхаарлыг хандуулахаас өөр аргагүйд хүргэсэн.

Үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн улс орнууд эдийн засгийн өсөлт хөгжлөө нийгэм, экологийн асуудалтай холбон үзэх боллоо.

Ялангуяа НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд хөгжил, орчны асуудалд онцгой анхаарч 1972, 1992 онуудад хоёр удаа дэлхий дахиныг хамарсан НҮБ-ын

¹ Монгол улс XXI зуунд УБ., 1997, х.72-101

хэмжээний бага хурал зарлан хуралдуулж, хүн төрөлхтний дараагийн зуунд мөрдөх гол чиг баримжааг тодорхойлжээ.

Энэхүү чиг баримжаа болсон гол баримт бичиг бол 1992 онд Рио де Жанейрод баталсан "XXI зууны мөрийн хөтөлбөр" юм. 1997 оны 6 дугаар сард НҮБ-ын тусгай 19 дүгээр чуулганаар төр, засгийн тэргүүн нар дээд түвшний хэмжээнд цуглаж байгаль орчин хөгжлийн асуудлыг дахин нухацтай хэлэлцэж төгсгөлийн баримт бичиг батлан гаргав.

Эдгээр баримт бичгүүд нь хөгжиж буй орнуудын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, хурдасгах, улс гүрэн тус бүрийн болон тэдгээрийн өөр хоорондын эдийн засгийн бодлогыг боловсруулах, ядууралтай тэмцэх, ухаалаг хэрэглээний бүтцийг тодорхойлох, хүн амын эрүүл ахуй, хотжилт, суурьшилт, уур амьсгалын өөрчлөлт, усны нөөц хангамжийг зохицуулах, газар ашиглалт, эрчим хүч, агаар орчны талаар зөв бодлого явуулах, химийн хорт бодис, хог хаягдлыг багасгах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, ойн аж ахуйг хөгжүүлэх зэрэг хоорондоо уялдаа бүхий асуудлыг шийдэх арга хэмжээ, механизмыг тодорхойлсон байна.

Нийгмийн хөгжил гэж юу болохыг хүн төрөлхтний амьдралын туулж ирсэн янз бүрийн замналыг шинжлэн дүгнэх үндсэн дээр тодорхойлох байдал философи, нийгмийн сэтгэлгээний түүхийн туршид ноёрхож иржээ. Орчин үед нийгмийн хөгжил нь түүхэн ба өнөөгийн, байгалийн ба нийгмийн, дотоод ба гадаад, тухайн орны ба олон улсын, материаллаг ба оюун, хэвийн ба гэнэтийн зэрэг олон янзын хүчин зүйлийн харилцан үйлчлэлийн үр дүн болж байна.

Бодит байдлыг тэмдэглэж буй бидний ойлголтын агуулга хэдийчинээ өөрчлөгдөж байна төдийчинээ бидний мэдлэг өөрчлөгдөн хувьсаж байна гэсэн үг юм.

Нийгмийн хөгжил гэж юу болох тухай янз бүрийн онолын баримтлал философи, социологи сэтгэлгээний түүхэнд зэрэгцэж болон өрсөлдөн оршиж ирсэн нь нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч нь юу болохыг тэдгээр баримтлал бие биеэсээ ялгаатай тайлбарлагддагаараа нягт уялддаг. Тийм тайлбаруудыг шинжлэх нь түүхэн төдийгүй шинжлэх ухааны практикийн чухал ач холбогдолтой.

Нийгэм бол хүмүүсийн үйл ажиллагаа, харилцааны цогц систем юм. Харин энэ харилцаанд үйлдвэрлэл явуулж буй хүмүүсийн үйл ажиллагаа нь нийгмийн амьдрал болж байдаг. Чухамдаа нийгмийн үйлдвэрлэл, харилцаа, оюун санааны үйл ажиллагаанд хүмүүс боловсорч нийгэм тасралтгүй өөрчлөгдөж байдаг. Нийгмийн

амьдрал ингэж өөрийн хуулиар хөдөлж хувьсаж, нийгэм хөгжлийн нэг шатнаас нөгөөд шилжиж иржээ. Энэ бол нийгмийн өөрийн хөгжил юм. Нийгмийн өөрийн хөгжлийн шалтгаан хөдөлгөгч хүчний асуудлыг олон янз байдлаар авч үзсээр иржээ.

Нийгэм-хөгжил хэмээх ойлголт нь нийгмийн зохистой зохион байгуулалт болох иргэншилд холбогдуулж авч үзэхэд хөгжил бол хуучин буюу нэгэнт байгаа энгийн, бас зохих утгаар доод зэргийг заавал халдаг биш, харин тодорхой нөхцөлд тэдгээрийг гарцаагүй хадгалан үлдэж байдаг байна. Хөгжил бол тухайн юм зохистой оршихуйгаа ханган өөрчлөгдөхүй мөн. Г.В.Ф.Гегель нийгэм түүхийн өөрчлөлт хөгжилтийн тасралтгүй үйл явцыг анхааран авч үзэж түүхийг урагшлах хөдөлгөөн гэж ойлгож байжээ. Хүн төрөлхтний дэвшлийн тухай соён гэгээрүүлэгчдийн үзэл санааг өвлөн авч хувьсгалын дараах үеийн Европын түүхийн туршлагыг анхааран, түүний зарим хэсгийг улам гүнзгийрүүлжээ.

Нийгэм түүхийн үзэгдлийг тайлбарласан түүний тайлбар нь түүхэнд болж буй бүх юмс хөгжил эхлэхээс өмнө өөртөө оршиж байдаг гэж үзсэн нь хийсвэр шинжтэй гэж хэлж болно. Нийгмийн тухай үзэл сургаалын систем дотор Г.В.Ф.Гегелийн үзэл томоохон байр суурь эзэлдэг. Зохиол бүтээлдээ Гегель хүн төрөлхтний нийгэм түүхийн үйл явцыг өөрийн байр суурин дээрээс тодорхойлж тайлбарлажээ.

Нийгмийн хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйлийг тайлбарласан газар зүйн, хүн ам зүйн, нийгэм-дарвинизмын нийгмийн сэтгэл зүйн, соёл иргэншлийн зэрэг олон тооны урсгал чиглэл шинэ үеийн философи нийгмийн сэтгэлгээнд бий болсон нь бүгд л нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүчний тухай асуудлаар буй болсон байна.

Гегелийн үзэл дээр үндэслэгдсэн формацын онолын гол мөн чанар бол нийгмийн амьдралын янз бүрийн салбарын дотроос эдийн засгийн салбарыг гол болгон ялгаж, нийгмийн харилцааны бүхий л цогцолбор дотроос үйлдвэрлэлийн харилцааг нийгмийн бусад бүх харилцааг тодорхойлох үндсэн бөгөөд анхдагч харилцаа гэж үздэг явдал юм. Марксизмын формацын онолын үзэл санааг XX зуунд хөгжүүлсэн В.И.Ленин "...тухайн үйлдвэрлэлийн харилцаануудын нийлбэр болсон нийгэм-эдийн засгийн байгуулал (формац) гэдэг ойлголтыг олж тогтоон, ийм байгууллын хөгжил бол байгаль түүхийн процесс мөн гэж тогтоогоод, нийгмийн судлалыг анх удаа шинжлэх ухааны үндэстэй болгосон юм" гэж формацын онолын ач холбогдлыг дүгнэжээ¹.

¹ Ленин В.И. Пол. Собр. Соч. Т.1, х.131

Марксист формацийн онолын тухай маргаан Марксаас хойш тасралтгүй өрнөсөөр ирсэн бөгөөд ялангуяа өнөө үеийн нийгмийн байгуулалтын онолын асуудалтай нягт уялдаатайгаар Марксыг дэмжигчид ба шүүмжлэгчдийн дунд энэ маргаан байнга явагдсаар байна. Уг маргааны нэг зүйл нь "Улс төрийн эдийн засгийн ухааны шүүмжлэл"-д зохиолын "Оршил"-доо Марксын тэмдэглэсэн Нийгмийн эдийн засгийн формацийн дэвшилтэт эрин үеүд, тухайлбал, "Азийн, эртний Грек, Ромын, феодалын, орчин үеийн хөрөнгөтний үйлдвэрлэлийн аргыг ерөнхийд нь нийгмийн эдийн засгийн формацын дэвшилттэй эрин үеүүд" хэмээсэн тодорхойлолт болно.

Г.В.Ф.Гегель дэлхий дахины түүхийг: 1. Дорно дахины ертөнц, 2. Грекийн ертөнц, 3. Ромын ертөнц, 4. Германы ертөнц гэсэн дөрвөн үед хувааж үзсэнтэй Марксын дээрхи формацын дэвшлийн асуудал нь холбоотой гэж үзэх үндэстэй билээ.

Марксын энэхүү үзэл санааг нэг хэсэг нь нийт ард түмэн түүхэн хөгжлийнхээ явцад заавал дайран өнгөрөх ёстой нийгмийн системүүдийн дарааллын тухай онолын илэрхийлэл гэж тайлбарладаг. Энэ тайлбарлал нь формацын онолын 5 гишүүнт бүдүүвчид хүргэсэн юм.

Нийгэм эдийн засгийн формацийг ойлгох К.Марксын ойлголт "Капитал"-д үлэмж хэмжээгээр гүнзгийрчээ. Формацыг хэрэг дээрээ үйлдвэрлэлийн зарим нэгэн голлон хөтлөгч аргатай зуршмал зүйл нь болсон суурьтай, түүнд тохирсон давхрагатай, өөрийг нь бүрэлдүүлэгч ангиудын аж төрөх ёстойн дээр бүрэлдэхүүнд нь орж байгаа эдгээр хэсгүүд хоорондоо диалектик харилцан үйлчлэлд байдаг тийм нийгмийн бүхэл бүтэн амьд махбодийн нь хувьд авч үзсэн юм. Үүний хамт Маркс нийгэм-эдийн засгийн формацыг зөвхөн тухайн нийгмийн эдийн засгийн бүтцийг бүрдүүлэгч үйлдвэрлэлийн тодорхой харилцаануудын нийлбэр цогцынх нь хувьд авч үзэж товчилсон тодорхойлолтыг хэрэглэж байв. Маркс "Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэхэд" зохиолын "Оршил"-д формацыг дэлгэрэнгүй ойлгох байдлаар түүний бүтцийн бүх бүрэлдэхүүн үндсэн хэсгийг (үйлдвэрлэх хүч, үйлдвэрлэлийн харилцаа, давхрагын хэлбэрүүд) тоочсон байдаг. Нийгэм-эдийн засгийн формац гэдэг бол үйлдвэрлэх хүчний тодорхой шинж чанар, төвшин, мөн үйлдвэрлэлийн харилцааны тодорхой шинж чанарын үндсэн дээр гарч ирэх нийгмийн хөгжлийн зохих төвшин дэх түүний орших ахуйн түүхэн тодорхой хэлбэр юм. Нийгэм эдийн засгийн формацын категори Марксын сургаалд арга зүйн асар их роль гүйцэтгэсэн. Энэ категори адил төстэй шинж байдал, нэгдмэл нэг зүй тогтлууд бүхий нийгмийн тодорхой бие махбодь

болохынхоо хувьд янз янзын улс орон, эрин үеийн нийгмийн дэг журмыг нэгтгэн дүгнэсэн байдлаар авч үзэх үндэс болж тэгснээрээ хүний нийгмийн түүхэн хөгжлийн нэгдмэл чанарыг илрүүлэн гаргах боломж өгдөг гэж марксистууд үнэлдэг. Нийгэм-эдийн засгийн формацын ухагдахуун бол нийгмийн түүхийн үе шатуудын шинжлэх ухааны үечлэлийг тогтоох болон бие биенийхээ халааг авагч үе шатуудын хоорондын учир шалтгаан, генезисийн залгамж чанарыг тогтоохын хамт хөгжлийн янз янзын түвшинд байгаа улс орон, ард түмнүүдийн хоорондын харилцан үйлчилгээг илрүүлэн тэдгээр үе шатуудын хуулиар дэс дараалах чанар болохынх нь хувьд түүхэн процессыг ухан ойлгох боломжийг олгодог юм. Нэг формац нөгөө формацаар солигдох явдал диалектик байдлаар үсрэнгүйгээр явагддаг, гэхдээ нөгөө талаас "газар дэлхийн түүхийн эрин үеүүд бие биеэсээ хатуу хязгаарлагаар хийсвэрээр зааглагддаггүйн нэгэн адил нийгмийн түүхийн эрин үеүүд тэгж зааглагдахгүй" гэж Маркс үзжээ¹.

К.Маркс хүн төрөлхтний түүх объектив зүй тогтлоор хөгждөг гэж үзэхдээ түүнийг эдийн засгийн шалтгаантайгаар тайлбарладаг. Үүнд, тэрээр "Капитал" зохиолдоо: "Эдийн засгийн нийгмийн формацын хөгжлийг би зүй ёсны түүхэн процесс гэж үзэж байна..." гэж хэлсэн юм². Тэгээд Маркс: хүмүүс үүсэж гарахад нь тохирох объектив нөхцөл ч байхгүй, объектив зайлшгүй шаардлага ч бүрэлдээгүй байхад нийгмийн байгууллыг дур зоргоороо бий болгож чадахгүй юм. Хүмүүс түрүү үеэсээ үйлдвэрлэх хүчний тодорхой төвшинг хүлээж аваад түүнд зохицдог, бас түүнд тохирсон харилцаа тэдний хооронд бүрэлдэн тогтдог. Нийгэм хөгжлийн зүй ёсны үе шатуудыг алгасан үсэрч ч чадахгүй, түүнийг удирдамж гарган халж ч чадахгүй гэсэн. Гегель ч мөн ийм санаа хэлж байсан.

Янз янзын улс орон дахь нийгэм, эдийн засгийн формацын хөгжил өвөрмөц шинжийнхээ ул мөрийг формацын хөгжилд үлдээдэг, түүний оршин тогтнох цаг хугацааг богиносгож, эсвэл уртасгаж байдаг, янз янзын дотоод гадаад үй түмэн хүчин зүйлээс шалтгаалж байдаг гэж Маркс үзээд бичихдээ аливаа улс үндэстэн бусдаасаа суралцаж болох ба суралцах ч ёстой, хэрэв шинэ нийгмийн хөгжлийн хуулиудыг таньж мэдвэл тэр шинэ нийгмийн үе улирах зовлонг багасгаж намдааж болох юм гэжээ.

¹ Маркс К., Энгельс Ф. Соч.т.23, х.382.

² Маркс К., Энгельс Ф. Соч.т.23, х.10.

Нийгэм эдийн засгийн формацуудын хөгжих, солигдох процессыг салангид авсан нэг улс орон дээр биш, харин дэлхий дахины нэгдмэл нэг түүхэн процесс гэж үзвэл зохино гэж марксизм үзжээ.

Түүхийн хөгжлийн зүй тогтлыг ойлгохын тулд хүмүүсийг үйл ажиллагаанд сэдээгч тэр хүчийг таньж мэдэх нь чухал юм. Хүмүүсийн үйл ажиллагаа ямагт объектив нөхцөл, субъектив хүчин зүйлээр нөхцөлдөж байдаг. Объектив нөхцөл нь юуны урьд материаллаг юмс үзэгдэл хүмүүсийн бодитой үйл ажиллагаа, материаллаг харилцаа юм.

Чухамхүү эл материаллаг амьдралаас хүмүүс өөрийгөө, хэрэглээ хэрэгцээгээ ойлгож, тодорхой зорилгод сэдээгддэг. Тэр нь тодорхой үйл ажиллагаанд түлхдэг байна. Хүмүүсийн эл үйл ажиллагаа нь нийгмийн өөрийн хөгжил, хөдөлгөөний үндэс болдог.

Үйлдвэрлэх хүчний хөгжил дорой арилжаа түгжигдмэл газар үйлдвэрлэл, хэрэглээ хуучнаа давтан нэг хүрээнд эргэлдэж байдаг. Шинэ хэрэгцээ буй болж, үйлдвэрлэлийг сэдээх явдал мөн зогсдог. Үүгээр үйлдвэрлэх хүчний биет болон хүний талын хөгжил зогсонги байдалд орж нийгмийн хөгжил удааширдаг байна.

Үйлдвэрлэл, солилцоо хэрэглээний хөгжил бол шинэ хэрэгцээ төрүүлэх, нийгмийн үйлдвэрлэх хүчний хөгжлийг сэдээгч объектив хүчний нэг нь болж байна. Хүмүүсийг үйл ажиллагаанд сэдээгч нэг чухал зүйл бол субъектив хүчин зүйлс-хүмүүсийн өөрсдийн нь ухамсарт үйл ажиллагаа юм. Энд хүмүүсийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, удирдлага, оюуны үнэт зүйлсийг бүтээх үйл ажиллагаа багтаж байдаг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бол үйлдвэрлэгч олон түмний санаа зорилго, мэдлэг, дадлагаа хэрэгжүүлэх үйл явц төдийгүй, бусдад бүтээх хэрэгцээ хүсэл эрмэлзэл төрүүлэгч өвөрмөц механизм юм.

Ийм байдлаар нийгэм эдийн засгийн формацын хөгжлийн хөдөлгөгч хүчний асуудал марксизмд шийдвэрлэгдсэн байна.

Таван формац ээлжлэн солигдох явдал нь энэ онолын гол цөм нь биш юм гэхэд нэг язгуур үндэслэл гэдгийг мартаж болохгүй юм. Энэ онол ёсоор аливаа нийгмийн байгууллын үндэс болсон материаллаг баялагийн үйлдвэрлэлийн арга нь өөртөө түүхэн тодорхой материаллаг харилцааг багтааж байдаг бөгөөд тэдгээрийн нийлбэр цогц нь тухайн нийгмийн байгууллын эдийн засгийн бүтэц, бодит суурийг бүрдүүлдэг. Үүн дээр оюун санааны харилцаа, хууль эрх, улс төрийн давхрага сүндэрлэн түүнд нийгмийн ухамсрын тодорхой хэлбэрүүд нийцэн тохирч байдаг

байна. Уг онол нь нийгмийг эдийн засгийн хүчин зүйлээр, ингэхдээ нийгмийн үзэгдлүүдийн харилцан үйлчлэл, зөрчил тэмцэлд тулгуурлаж тайлбарласан байна.

Үүний зэрэгцээ нийгэм-эдийн засгийн формацийн тухай марксист онолыг онол, арга зүйн үүднээс шүүмжилсэн судалгаа манайд гарах боллоо.

Формацийн солигдол нь диалектик үгүйсгэлийн хэлбэрээр явагддаг гэж марксист үзсэн. Үүнд, энэ нь нийгэм, эдийн засгийн нэг формацийн дэвшилтэт бүхэн дараагийн нийгмийн байгуулалд дэвшин орж, харин тухайн нийгмийн байгууллын үеэ өнгөрөөсөн шинж нь тухайн шатандаа үлддэгээр тайлбарлагдах учиртай

Гегель түүхийн хөгжлийн явц дахь үгүйсгэлийг авч үзэхдээ: оршин буй бодит байдалд шинэ оюун санаа, шинэ түгээмэл зүйл сэтгэл ханахаа байдаг. Шинэ байгууллын үндэс соёо нь нааштай зүйл мэт, өөрөөр хэлбэл, шинэ байгууллын гэх мэт, хэлбэрээр батжихаасаа өмнө эхлээд сөрөг, сүйтгэгч хүч мэт гарч ирдэг. Ингэхээр хуучныг үгүйсгэсний үр дүнд шинэ байгуулал бий болдог байна. Шинэ байгуулал батжин тогтох үед болж буй эвдрэл сүйтгэлийг Гегель зөвтгөн үзжээ. Гегель шинэ зүйлд байдаг сөрөг зүйлүүдийг заахын хамт түүхийн хөгжлийн бүхий л үе шатанд зөвхөн эерэг зүйлүүдийг олж харж ингэснээрээ хүн төрөлхтний анхны байдалд эргэж очихыг зөвлөдөг тийм хүмүүсийг эрс шүүмжилсэн. Гегелийн хувьд туулж өнгөрсөн үе шат бүр, түр зуурын боловч бүхэлдээ дэлхий дахины хувьд нааштай байдаг.

Шат бүрийн эерэг агуулга нь цаашдын түүхэнд халагдсан хэлбэрээр хадгалагдан үлддэг гэж үзжээ. Үүнээс гадна Гегель нийгмийн хөгжлийн үйл явц нь шулуун дардан тэмцэлгүйгээр явагдахгүйг онцлон тэмдэглэжээ. Оюун санаа нь ямагт өөрийгөө даван туулж, өөрийнхөө эсрэг тэмцэл хийдэг. "Ийнхүү хөгжил нь органик амьдралд байдаг шиг, тэмцэлгүй явагдаж буй энгийн тайван үйл явц биш, харин өөрийнхөө эсрэг чиглэгдсэн хүнд хэцүү зүйл бөгөөд хүсээд ч байх ажил биш юм" хэмээн бичсэн байна¹. Гегель хүн төрөлхтний түүхийг түүхийн байнгын хөгжлийн үйл явц гэж ойлгосноо өөрчлөлтийн категориор илэрхийлжээ.

Гегелийн хувьд үгүйсгэл нь нэгэн удаагийн бус, харин төгсгөлгүй үйл явц юм. Тэрвээр энэ үйл явцад гурван элементийн холбоос олсон нь тезис-антитезис-синтез юм.

Түүний философид гурвал нь зөвхөн арга төдийгүй бас систем үүсгэгч үүрэг гүйцэтгэжээ. Гегелийн философийн бүхий л төлөв бүтэц нь гурвалсан горимд захирагдаж, гурвалын шаардлагын дагуу байгуулагджээ.

¹ Гегель Г.В.Ф. Философия права. М., 1990, х.339

Гегелийн философийн сурвалж нь сэтгэхүй (ухамсар) ба ахуйн адилсал юм. Юмс ба тэдгээрийн тухай санаа давхцан тохирно. Иймд сэтгэхүй дотоод тодорхойлолтоороо, мөн юмсын жинхэнэ уг чанар хоёр бол нэг утгатай юм.

Ингээд Гегель нийгмийн хөгжлийн уг сурвалжийн тухай асуудлыг дээрх зарчмын үүднээс тайлбарлажээ.

Объектив оюун ухаан бол доодоос дээдэд шилжих, хөгжих үйл явцад оршин буй нэгэн нэгдмэл, бүхэл юм. Гегель оюун ухаан хөгжих хөдөлгөгч хүч нь субъект объектын диалектик зөрчил мөн гэж үзсэн байна. Оюун ухаан энэ зөрчлийг даван өөрийн чөлөөт байдлыг ухамсарлахад дэвшилт хийнэ. Оюун ухааны субстанц нь чөлөөт байдал буюу өөрөөр хэлбэл нөгөөгөөс хараат бус байдал өөрөө өөртөө харилцахуй мөн гэжээ¹.

Гегелийн үзлээр жинхэнэ чөлөөт байдал бол зайлшгүйг үгүйсгэхэд бус, харин түүнийг ухаарахад, түүний сэтгэхүйн шинжтэй агуулгыг нээн илрүүлэхэд оршдог байна.

Хүн төрөлхтний түүх бол чөлөөт байдлыг, тэгэхдээ оюун санаа сэтгэлгээний чөлөөт байдлыг ухамсарлах дэвшил юм.

Түүний үзлээр чөлөөт байдал бол дур зориг биш, тодорхой нөхцөлөөр хязгаарлагдсан зүйл юм. Чөлөөтэй байна гэдэг бол хүн хийж байгаа зүйлийнхээ хязгаар хийгээд зайлшгүй чанарыг ухамсарлахыг хэлнэ.

“Хэрвээ би ухаалаг зүйлийг хүсвэл, тусгаарлагдсан хувь хүн бус, харин зан суртахуунт байдлын ойлголтод зохицуулан ажиллах болно. Ёс суртахууны үйлдэлд өөрийгөө биш, мөн чанарыг гол болгоно”² гэж Гегель үзсэн нь буй.

Хүн чөлөөт байдлаа ухамсарлах нь онцгой чухал. Боол нь өөрийн чөлөөт байдлыг мэдэж, сэтгэдэггүй тул боол болдог гэж үзэж байв. “Эрх чөлөө нь ямар нэг юмыг тэр чөлөөлж, түүний агуулга нь өөртэйгөө адил болох тэр үед л, ингэхлээр чөлөөт байдал, чөлөөт байдлаа чөлөөлсөн тэр үед л, жинхэнэ бий болдог”.

Нийгэм дэх хэсэг хүмүүсийн дураараа үйлдлийг даван туулж, хязгаарлаж болдог. Нийгэм дэх чөлөөт байдал бол хэсэг хүмүүсийн дур зоргоороо аашлахыг даван туулах явдал мөн гэж үзсэн нь чухал ач холбогдолтой санаа юм. Хүмүүс хүсэл зоригоо тодорхой биш байдлаар дурын үйлдэл мэт биш, харин хязгаарлагдмал хүсэл

¹ Гегель Г.В.Ф. Энциклопедия философских наук. Т.3. М., 1956, х.329

² Гегель Г.В.Ф. Энциклопедия философских наук. Т.3. М., 1956, х.45

зориг мэт илэрхийлдэг. Хүсэл зоригийн энэ хязгаарлал нь эрхийн хэм хэмжээ, хуулиар зохицуулагдаж, өөрөөр хэлбэл, эрхийн харилцааны хүрээнд хэрэгжиж байдаг байна. Эрх бол чөлөөт байдлын биет ахуй нь болж өгдөг.

Ийм байдлаар Гегель нийгэм, түүхийн хөгжлийн уг сурвалжын асуудлыг боловсруулжээ. Ингэж тайлбарлахдаа Гегель нийгмийн амьдралын оюун санааны амьдралын хөгжлийг авч үзэн, улмаар хаана оюун санааны хөгжил өндөр байна, нөгөө талаас чөлөөт байдлын ухамсарт хүрсэн байна тэнд нийгмийн хөгжил өндөр түвшинд байна гэсэн үзэл санааг дэвшүүлжээ.

Гегелийнхээр чөлөөт байдлын ухамсарт бүрэн төгс хүрсэн улс үндэстэн бол Герман юм. Эндээс үндэслэж хүн төрөлхтний хөгжлийн оргил нь Герман юм гэсэн дүгнэлтийг Гегель хийжээ.

Гегелийн энэ үзлээс аливаа нийгмийн хөгжлийг тодорхойлж буй хүчин зүйл бол тухайн нийгмийн оюун санааны (эрх, ёс суртахуун, шашин, философи гэх мэт) амьдралын хөгжлийн түвшин гэж ойлгож байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн ухамсрын түвшин уг нийгмийнхээ хөгжлийг тодорхойлно гэсэн үг юм.

Харин марксизмд нийгмийн ухамсар нь ахуйгаа тусгаж байдаг хэмээн номлодог. Ер нь нийгмийн амьдралын нэг үндсэн хүрээ нь оюун санааны амьдрал юм. Гэхдээ нийгмийн оюун санааны амьдрал маш өөрчлөмтгий олон янзын бүтэц, элемент бүхий байдаг.

Гегель тухайлж нийгмийн оюун санааны хүчин зүйлд урлаг, шашин, философи зэргийг хамааруулан авч үзжээ. Бүтцийн эдгээр элемент нь туйлын оюун санааны хөгжлийн дээд үе шатны хэлбэрээр гарч ирдэг. Тэр нь эцсийн тодорхойлолттой холбоогүй, бүрэн чөлөөтэй байдаг тул туйлын шинжтэй юм. Мэдэрч ажиглахаас (урлаг) төсөөлөлд (шашин) түүнээс ойлголтын сэтгэхүйд (философи) хүрэх замаар хөгждөг гэж үзжээ.

Нийгмийн оюун санааны хүчин зүйлсийг нийгмийн хөгжлийн тодорхойлогч хүчин зүйл хэмээн үзэж буй Гегелийн үзэл баримтлал бол нийгмийг оюун санааны хүчин зүйлээр тайлбарладаг үзэл баримтлалын дотор томоохон байр суурь эзлэх ёстой. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд хэвлэгдэн гарч буй философийн сурах бичиг, гарын авлагад Гегелийн боловсруулсан нийгмийн тухай үзэл баримтлалыг тусгайлан авч судлах хандлага гарч ирж байна.

Монголын нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшинг Гегелийн үзэл баримтлалын үүднээс авч үзвээс үнэхээр үнэний ортой мэт. Учир нь аливаа нийгмийн оюун

санааны хүчин зүйлсийн хөгжил өндөр түвшинд байна төдийчинээ тухайн нийгмийн хөгжил дэвшил нь сайн байдаг ажээ.

Зарим улс орон яагаад өндөр хөгжсөн, зарим орон хөгжлийн хувьд яагаад хоцрогдох болов, үүнд ямар хүчин зүйл нөлөөлж байна вэ гэсэн асуулт орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны өмнө тавигдсаар байна.

Жишээлбэл тэр шалтгааныг ямар нэгэн хэмжээгээр танин мэдсэний үндсэн дээр Монгол Улс дунд болон урт хугацаанд зайлшгүй үр дүнд хүрэх хөгжлийн бодлогоо зөв томъёолох бололцоо бүрдэх болно.

Монголын соёлын онцлогийн талаархи асуудлыг нүүдлийн мал аж ахуйн үүсэл хөгжлийн үйл явцтай холбон авч үздэг байр суурь зүйтэй юм.

Ургамал, жимс түүж, ан амьтныг элдэв аргаар агнах явдлыг бодвол мал аж ахуй эрхлэх нь бүтээх шинжтэй үйлдвэрлэл юм. Хүмүүс үйлдвэрлэлийн хэрэгслийг үйлдвэрлэх үйл явц өргөжиж энэ талаар нэлээд ололт, туршлага хуримталж ирэхэд нийгмийн үйлдвэрлэх хүч нь мал аж ахуй, газар тариалан хоёрыг тус тусад нь эрхлэх боломжийг төрүүлсэн тэр түвшинд хүрчээ.

Мөн цаашлаад малч түмний аж ахуйн төрх төлөв нүүдлээ эрхлэхэд зохимжтой, хөдөлгөөнт шинжийг олжээ.

Ингэж үүсэж хөгжсөн аж ахуйн хэвшил буюу нүүдлийн мал аж ахуй түүнийг эрхэлж буй хүмүүсийн эд өлөгийн соёлыг үлэмж өөрчилсөн байна. Гэр орон, гэрийн тавилга, ахуй байдлын хэрэглэл, хувцас хунар, ер амьдралын бүхий л хэвшил нь энэхүү нүүдлийн мал аж ахуйг хамгийн зохистой эрхлэхэд дээд зэргээр тохирсон байна.

Мал маллах, ба адуулах явцад гар урлалын маягтай үйлдвэрлэлийг малчид хослон эрхэлж иржээ.

Ер нь нүүдлийн мал аж ахуй бол зөвхөн мал адуулах, гар урлал эрхлэх буюу эдүгээ хүртэл хэрэглэгдэж ирсэн нэр томъёогоор бол зөвхөн материаллаг үйлдвэрлэлийг төдийгүй мөн оюуны үйлдвэрлэлийг багтаасан цогцолбор шинжтэй аж ахуй юм.

Жилийн дөрвөн улиралд бэлчээр шүтэн мал маллах нүүдлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь тэдний сэтгэхүйн өвөрмөц онцлогийг ч нөхцөлдүүлжээ. Энэ нь нүүдлийн мал аж ахуйг эрхлэх үйлдвэрлэл явуулахад шаардагдах одон орон, газар зүй, цаг уур, ургамал судлал, мал эмнэлэг, үржил сонголт зэрэгтэй холбогдсон

туршлагын мэдлэг, домог зүй болон билэг зүйн бүтээл тэргүүтнээр тодорхойлогдож байлаа.

Энэ бүхний үр дүнд нүүдлийн аж төрөх ёс буюу номадизм хэмээгдэх хүмүүсийн амьдралын өвөрмөц хэвшил бүрэлдэн тогтжээ.

Эдүгээ цаг үед Монголчууд нийт хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг чиг хандлагын дагуу өөрийн гэсэн онцлогтой соёлоо хадгалан авч хөгжлийн замаар явж байна.

Монголын түүхэнд монголчуудын соёл, тэдний нийгмийн зохион байгуулалт хоёрын аль нь алиныгаа тодорхойлж байв? Энэ тухай нэг мөр хариулт өгөх боломжгүй юм. Учир нь, нөхцөл байдлын улмаас аль нь ч алиныхаа шалтгаан болж болдог.

Энэ нь нийгмийн хөгжлийн явцад иргэншлийн шинэ маяг бүрэлдэн тогтох, нийгмийн шинэ төлөв байдал төлөвших, нийгмийн болон бие хүний ухамсар хөгжих энэ бүх үйл явц чухам соёлын нөлөөнд өрнөдөг ажээ.

НОМ ЗҮЙ

1. Гегель Г.В.Ф. Философия права. М., 1990, х.339
2. Гегель Г.В.Ф. Энциклопедия философских наук. Т.3. М., 1956, х.329
3. Гегель Г.В.Ф. Энциклопедия философских наук. Т.3. М., 1956, х.45
4. Дашпүрэв Д. Этапы модернизации монгольского общества. УБ., 1995, х.173
5. Eisenstadt S. Tradition, Change and Modernity. 1973, х.66
6. Ленин В.И. Пол. Собр. Соч. Т.1, х.131
7. Маркс К., Энгельс Ф. Соч.т.23, х.382.
8. Маркс К., Энгельс Ф. Соч.т.23, х.10.
9. Монгол улс XXI зуунд УБ., 1997, х.72-101